



**НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2016 оны 11 сарын 02 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

**Хурлын Төлөөлөгчдийн бүрэн эрхийг
хүлээн зөвшөөрөх тухай**

Сонгуулийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.11 дэх заалт, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1 а дахь заалтыг тус тус үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Анхдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдийг сонгох 8 дахь удаагийн сонгуулиар Хурлын Төлөөлөгчөөр сонгогдсон төлөөлөгчдийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрүүлэх тухай Дүүргийн Сонгуулийн хорооны даргын илтгэлийг хэлэлцээд хавсралтад нэр дурдсан 35 төлөөлөгчийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрсүгэй.


ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ



Н.ОЮУНГЭРЭЛ

1150100003

Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2016 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн Анхдугаар
Хуралдааны 01 дүгээр тогтоолын хавсралт



Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд
сонгогдсон Төлөөлөгчдийн нэрс

Д/д	Тойргийн дугаар	Нэр дэвшигчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр	Намын харъяалал	Авсан саналын тоо	Хувь
1.	1	Нямцэцэгийн Сайнболд	МАН	832	66.24
2.	2	Содномбалжирын Мөнгөнсар	АН	617	51.84
3.	3	Жамсрангийн Чимэдцогзол	МАН	1249	65.50
4.	4	Сумъяагийн Отгонсүрэн	МАН	1049	60.50
5.	5	Сосорбарамын Амарбаясгалан	МАН	1108	65.60
6.	6	Чадраабалын Болормаа	МАН	1638	67.52
7.	7	Цэвээний Дуламжав	МАН	2509	48.97
8.		Дашцэрэнгийн Баянбат	МАН	2445	47.72
9.		Дугарын Мөнхчулуун	АН	2341	45.69
10.	8	Лувсанцэдэнгийн Баярсайхан	МАН	1104	63.12
11.	9	Намхайн Оюунцэцэг	МАН	1765	60.55
12.		Цэрэндэлэгийн Бугасүрэн	МАН	1540	52.83
13.	10	Жавзийгийн Лхагвасүрэн	МАН	2449	70.23
14.		Дэчингийн Нэмэхбат	МАН	2307	66.16
15.	11	Дэмбэрэлийн Отгонбаатар	МАН	1359	59.34
16.	12	Очирсүхийн Есөнтөмөр	АН	2881	51.94
17.		Батаагийн Батхуяг	АН	2719	49.02
18.		Шагдарсүрэнгийн Батсүрэн	АН	2452	44.20
19.	13	Гэндэнгийн Бадамгарав	МАН	1774	56.28
20.		Загдсүрэнгийн Бямбажав	МАН	1732	54.95
21.	14	Дамжингийн Бат-эрдэнэ	МАН	1791	67.48
22.		Лхаасүрэнгийн Ариунтуяа	МАН	1752	66.01
23.	15	Баасанжаргалын Цогзолмаа	МАН	1710	53.42
24.		Сосорбарамын Энхтайван	МАН	1690	52.80
25.	16	Бүлтэнхүүгийн Мөнхбат	МАН	2538	49.75
26.		Дэлэгпунцагийн Ядамжав	МАН	2482	48.66
27.		Тогтохын Идэрцагаан	МАН	2461	48.25
28.	17	Хашбаатарын Алтаншагай	МАН	2395	47.28
29.		Ванданчимэдийн Хүрэлбаатар	МАН	2322	45.83
30.		Дашзэвэгийн Мөнхтөр	МАН	2293	45.26
31.	18	Баавгайхүүгийн Насанбат	МАН	2156	60.8
32.		Дамдинсүрэнгийн Мөнхбат	МАН	2094	59.1
33.	19	Нэргүйн Оюунгэрэл	МАН	2213	49.09
34.		Жадамбын Алтантуул	МАН	2136	47.38
35.		Ойдовын Цэнддорж	МАН	1703	37.78



НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2016 оны 11 сарын 02 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Хурлын даргыг сонгож батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.4, 18 дугаар зүйлийн 18.1.1б заалтыг үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Анхдугаар Хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Анхдугаар Хуралдаанд оролцож буй Төлөөлөгчдийн санал хураалтын дүнгээр олонх буюу 100 хувийн санал авсан 14 дүгээр тойргоос сонгогдсон Төлөөлөгч Дамжин овогтой Бат-Эрдэнийг Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргаар сонгож баталсугай.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ



Н.ОЮУНГЭРЭЛ

11 0100003



НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2016 оны 11 сарын 02 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Дүүргийн Засаг даргад нэр
дэвшүүлж, уламжлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1г, 25 дугаар зүйлийн 25.1, 26 дугаар зүйлийн 26.2 дахь заалтыг тус тус үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Анхдугаар Хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Анхдугаар Хуралдаанд оролцож буй Төлөөлөгчдийн санал хураалтын дүнгээр олонх буюу 100 хувийн санал авсан Жамсран овогтой Эрдэнэбатыг Чингэлтэй дүүргийн Засаг даргад нэр дэвшүүлж, Нийслэлийн Засаг даргад уламжилсугай.

ХУРЛЫН ДАРГА



Д.БАТ-ЭРДЭНЭ

1150100003



НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2016 оны 11 сарын 21 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

Хурлын Тэргүүлэгчдийг сонгож
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.16, 23 дугаар зүйлийн 23.5, 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалтыг тус тус үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Хуралдаанд оролцсон Төлөөлөгчдийн олонхийн саналыг авсан дараах нэр бүхий 7 Төлөөлөгчийг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээр сонгож баталсугай. Үүнд:

1. Д.Бат-Эрдэнэ /МАН/
2. С.Амарбаясгалан /МАН/
3. Л.Баярсайхан /МАН/
4. Ц.Дуламжав /МАН/
5. Х.Алтаншагай /МАН/
6. Н.Сайнболд /МАН/
7. Б.Батхуяг /АН/

2. Хууль тогтоомжийн хүрээнд бүрэн эрхээ хэрэгжүүлж, идэвх санаачилгатай ажиллахыг Хурлын Тэргүүлэгчдэд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Д.БАТ-ЭРДЭНЭ

1150100011



НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2016 оны 11 сарын 21 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

Хурлын хороод байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1.в, 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалтыг үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хэлэлцэх асуудлыг урдчилан бэлтгэх, санал дүгнэлт гаргах, шийдвэрийн биелэлтийг хянан шалгах чиг үүрэг бүхий дараах хороодыг байгуулж, ажиллуулсугай. Үүнд:

- 1.1. Эрх зүй, Нутгийн удирдлагын хороо
- 1.2. Эдийн засаг, төсвийн хороо
- 1.3. Төсвийн зарцуулалтын хяналтын хороо
- 1.4. Ногоон хөгжил, газрын харилцааны хороо
- 1.5. Хот байгуулалт, үйлдвэрлэл үйлчилгээ, гэр хорооллын хөгжлийн хороо
- 1.6. Нийгмийн хөгжлийн хороо
- 1.7. Ёс зүй, өргөдлийн хороо

2. Хороодын бүрэлдэхүүнд дараах Төлөөлөгчдийг баталсугай. Үүнд:

2.1. Эрх зүй, Нутгийн удирдлагын хороо

Дарга: Д.Ядамжав
Гишүүд: Д.Мөнхтөр
Д.Баянбат
З.Бямбажав
Л.Ариунтуяа
Ц.Бугасүрэн
Д.Мөнхчулуун

2.2. Эдийн засаг, төсвийн хороо

Дарга: Н.Оюунцэцэг
Гишүүд: Д.Мөнхбат
Л.Баярсайхан
Б.Батхуяг
Д.Бат-Эрдэнэ
Н.Сайнболд
Ц.Бугасүрэн

2.3. Төсвийн зарцуулалтын хяналтын хороо

Дарга: С.Мөнгөнсар
Гишүүд: Ж.Лхагвасүрэн
Б.Батхуяг
С.Энхтайван

1150100015

С.Отгонсүрэн
Ш.Батсүрэн
О.Есөнтөмөр

2.4. Ногоон хөгжил, газрын харилцааны хороо

Дарга: Б.Цогзолмаа
Гишүүд: Г.Бадамгарав
В.Хүрэлбаатар
О.Цэнддорж
Н.Оюунгэрэл
Д.Ядамжав
Д.Баянбат

2.5. Хот байгуулалт, үйлдвэрлэл үйлчилгээ, гэр хорооллын хөгжлийн хороо

Дарга: Б.Насанбат
Гишүүд: Ц.Дуламжав
Б.Мөнхбат
Д. Отгонбаатар
Ч.Болормаа
Т.Идэрцагаан
Ш.Батсүрэн

2.6. Нийгмийн хөгжлийн хороо

Дарга: Г.Бадамгарав
Гишүүд: Д.Нэмэхбат
Ж.Чимэдцогзол
О.Есөнтөмөр
Б.Насанбат
Ж.Алтантуул
С.Мөнгөнсар

2.7. Ёс зүй, өргөдлийн хороо

Дарга: Л.Ариунтуяа
Гишүүд: Х.Алтаншагай
Д. Мөнхтөр
С.Амарбаясгалан
З.Бямбажав
Д.Нэмэхбат
Д.Мөнхчулуун

3. Хурлын хороодын ажиллах журмыг батлан, мөрдөн ажиллуулахыг Хурлын Тэргүүлэгчдэд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Д.БАТ-ЭРДЭНЭ



НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2016 оны 11 сарын 21 өдөр

Дугаар 06

Улаанбаатар хот

Хурлын хуралдааны дэг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.14 дэх заалтыг үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны дэгийг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.
2. Хуралдааны дэгийг мөрдөж ажиллахыг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчид, Хурлын Ажлын албаны ажилтнуудад үүрэг болгосугай.
3. Энэхүү дэг батлагдсантай холбогдуулан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2012 оны 10 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.


ХУРЛЫН ДАРГА



Д.БАТ-ЭРДЭНЭ

1150100017

Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын 2016 оны 11 дүгээр сарын
21-ний өдрийн 06 тогтоолын хавсралт



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ДЭГ

/Шинэчилсэн найруулга/

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү дэгийн зорилт нь Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал түүний хороо, түр хороо, ажлын хэсгийн хуралдаан /цаашид хуралдаан гэх/-ыг зохион байгуулах, хуралдаанаар асуудал хэлэлцэх, санал хураах, шийдвэр гаргах, биелэлтийг хянаж тайлагнахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2. Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны зохион байгуулалтын үндсэн хэлбэр нь хуралдаан байх бөгөөд хуралдааны зохион байгуулалт, үйл ажиллагааг Монгол Улсын Үндсэн хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон энэхүү дэгээр зохицуулна.

1.3. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь Монгол Улсын Үндсэн хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн хүрээнд өөрийн бүрэн эрхэд хамаарах дүүргийн эдийн засаг, нийгэм, цаг үеийн бусад шаардлагатай асуудлуудыг бие даан хэлэлцэн шийдвэрлэнэ.

1.4. Хуралдаанд хууль дээдлэх, асуудлыг чөлөөтэй хэлэлцэж, цөөнхийн саналыг хүндэтгэн сонсож, олонхын саналаар шийдвэрлэх зарчмыг удирдлага болгоно.

Хоёр. Хуралдаан түүний зохион байгуулалт

2.1. Хурал нь Монгол Улсын Үндсэн хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасан асуудлууд болон Хурлын байгууллагаас сонгуулийн бүрэн эрхийн хугацаанд хэрэгжүүлэх ажлын үндсэн чиглэл, Хурал, Тэргүүлэгчдийн ажлын төлөвлөгөөнд тусгагдсан асуудлуудыг ээлжит болон ээлжит бус хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

2.2. Хурал өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлын зэрэгцээ эрх бүхий дээд шатны байгууллагаас шийдвэрлүүлэхээр шилжүүлсэн асуудал, Дүүргийн

Засаг дарга, Хурлын Төлөөлөгч, Тэргүүлэгчдээс өөрсдийн эрх хэмжээний хүрээнд хэлэлцүүлэхээр оруулсан асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж болно.

2.3. Хуралдааныг Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3, 23.4 дэх заалтыг үндэслэн дүүргийн Хурлын Тэргүүлэгчид зарлан хуралдуулна.

2.4. Хуралдаанд бүрэн эрх нь хүлээн зөвшөөрөгдсөн нийт Төлөөлөгчийн олонх нь оролцсноор ирцийг хүчин төгөлдөрт тооцно.

2.5. Хуралдаанаар хэлэлцэх асуудалтай холбогдуулан Төрийн болон Төрийн бус олон нийтийн байгууллага, албан тушаалтан, аж ахуйн нэгж, иргэд, хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөллийг урилгаар оролцуулж болох бөгөөд уг асуудлыг Хурлын дарга шийдвэрлэнэ. Урилгаар оролцогчид нь хуралдааны дэгийг чанд сахина.

2.6. Хуралдаанаар хэлэлцэх асуудлын илтгэл, гаргах шийдвэрийн төслийг асуудал оруулж байгаа эрх бүхий байгууллага, албан тушаалтан боловсруулж Хурлын Ажлын албанд цаасаар болон цахим хэлбэрээр албан бичгийн хамт ирүүлнэ.

2.7. Хуралдаанаар хэлэлцэх асуудлыг тухайн асуудлыг харьяалах хороо, нам эвслийн бүлгийн хурлаар урьдчилан хэлэлцүүлэх ба ажлын 5 хоногт багтаан хуралдаж, санал дүгнэлтээ Хурлын даргад өргөн мэдүүлнэ. Хороо, нам, эвслийн бүлгийн хуралдаанаас гарсан санал дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд танилцуулна.

2.8. Хуралдаан болон хэлэлцэх асуудлын талаар бэлтгэл ажлын төлөвлөгөө гаргах, санал дүгнэлт бэлтгэх, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилах, иргэд олон нийтийн санал авах хэлэлцүүлгийг зохион байгуулах ажлыг Хурлын Ажлын алба хариуцна.

2.9. Хуралдаанаар хэлэлцэх асуудалд холбогдох тооцоо, судалгаа, лавлагаа, гарах шийдвэрийн төслийг хавсаргаж Хурлын Төлөөлөгчдөд цахим хаягаар болон цаасан хэлбэрээр тараах бөгөөд энэхүү шаардлагыг хангаагүй асуудлыг хуралдаанаар хэлэлцэхгүй.

2.10. Хуралдааны байр, танхимыг бэлтгэх, төрийн сүлд, хүндэтгэлийн туг болон шаардлагатай техник, тоног төхөөрөмжийг Хурлын Ажлын алба, Засаг даргын Тамгын газрын ажилтнууд урьдчилан хангасан байна.

2.11. Хурлын хуралдааныг нээлттэй хэлбэрээр зохион байгуулна.

2.12. Хуралдаан эхлэхийн өмнө танхимд Монгол Улсын төрийн сүлд дууллыг эгшиглүүлнэ.

2.13. Хуралдаанаар хэлэлцэж буй асуудлын хүрээнд холбогдох зураг, хүснэгт, танилцуулга, дүрс, дуу бичлэг, биет зүйлс түүний загвар хэсгийг хуралдаанд үзүүлж болно.

2.14. Хурлын хуралдааны явцыг дуу, дүрс бичлэг, мэдээллийн бусад хэрэгслийг ашиглан баримтжуулна.

2.15. Хурлын хуралдаан болон Тэргүүлэгчдийн хуралдааны үед Хурлын дарга Хуралдааны үйл ажиллагааг дэгийн дагуу зохицуулахаар Хурлын алх ашиглаж болно.

2.16. Төлөөлөгчид хуралдаанд оролцохдоо хуралдааны дэг, хуралдааны даргын шаардлагыг биелүүлэх үүрэгтэй бөгөөд үг хэлэх, санал шүүмжлэл гаргах, асуулт тавих эрхийг дараах байдлаар эдэлнэ. Үүнд:

2.16.1. Үг хэлэх, санал шүүмжлэл хэлэх, асуулт асуух бүртээ хуралдаан даргалагчаас зөвшөөрөл авна.

2.16.2. Тогтоосон хугацаанд үг хэлэх, асуулт асуух эрхээ бусад Төлөөлөгчдөд шилжүүлэхгүй байх.

2.16.3. Үг хэлэх буюу асуулт тавих эрхээ эдлэхдээ бүдүүлэг үг хэллэг хэрэглэх, бусдыг доромжлох, нэр төрийг нь гутаах, басамжлах, яриаг нь таслах өөрийн саналыг дэмжүүлэх, бусдын саналыг үгүйсгэх зорилгоор аливаа үйлдэл үзүүлэх, хүч хэрэглэх зэрэг үйлдэл гаргахгүй байх.

2.16.4. Төлөөлөгч хэлэлцэж байгаа асуудал бүрээр эхний удаад 5 хүртэл минут, дараагийн удаад 3 хүртэл минутын хугацаагаар үг хэлнэ. Хуралдааныг 2 цаг тутамд 15 минутын завсарлагатайгаар явуулна.

2.17. Хурлын дарга, Тэргүүлэгчдийг сонгож батлах, дүүргийн Засаг даргад нэр дэвшүүлэх, хуралдаанаас гарах тогтоолын төслийг хэлэлцэж батлахад цаг тогтоохгүй.

2.18. Хуралдаанаар хэлэлцэх илтгэл, гарах шийдвэрийн төслийг Төлөөлөгчдөд урьдчилан танилцуулсан бол илтгэл тавихгүйгээр Төлөөлөгчдийн санал, дүгнэлтийг нэгтгэн сонсож, тогтоолын төслийг хэлэлцэж болно.

2.19. Хуралдаанаар хэлэлцэж байгаа асуудлыг ил болон нууц санал хураалтаар шийдвэрлэнэ.

2.20. Ил санал хураалтыг гар өргөж, эсхүл цахим тоолуураар, нууц санал хураалтыг санал хураах хуудсаар явуулна.

2.21. Санал хураалт явуулах үед төлөөлөгч санал өгөх эрхээ зөвхөн өөрөө эдлэх бөгөөд энэхүү эрхээ бусдад шилжүүлэх, бусад төлөөлөгчийн өмнөөс санал өгөхийг хориглоно.

2.22. Төлөөлөгч хүндэтгэн үзэх шалтгаанаар хуралдаанд хүрэлцэн ирэх боломжгүйд хүрвэл Хурлын дарга, Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргад мэдэгдэж хэлэлцэх асуудалтай холбоотой саналаа урьдчилан бичгээр ирүүлж болно. Төлөөлөгч хуралдаанаас гарсан шийдвэртэй танилцаж болно.

2.23. Төлөөлөгч нь нутаг дэвсгэрийн асуудлыг шийдвэрлэхтэй холбогдуулан тодорхой албан тушаалтанд асуулга тавьж хариу авах эрхтэй бөгөөд Төлөөлөгчийн тавьсан асуулгад хариуг бичгээр өгнө.

2.24. Асуулгын хариуг Тэргүүлэгчдийн хуралдаанд асуулга тавьсан Төлөөлөгч, эрх бүхий албан тушаалтанг оролцуулан хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах ба шаардлагатай бол тодорхой ажлын чиглэл бүхий шийдвэр гаргана.

2.25. Хуралдааны санал шүүмжлэлийг Төлөөлөгчдийн олонхын саналаар тасална. Шаардлагатай гэж үзсэн цөөнхийн саналыг тусгайлан хэлэлцэж хуралдааны шийдвэрт болон тэмдэглэлд тусгана.

2.26. Төлөөлөгч нь санал шүүмжлэлээ хуралдаан даргалагчид бичгээр өгч болно. Бичгээр өгсөн санал шүүмжлэлийг хурлын хороо, ажлын хэсэг, холбогдох албан тушаалтанд шилжүүлэх асуудлыг хуралдаан даргалагч шийдвэрлэнэ.

2.27. Хуралдааны дарга бичгээр ирсэн санал, асуулт, асуулгын талаар Төлөөлөгчдөд сонсгох, танилцуулж хэлэлцүүлэх, хэлэлцсэн асуудлаар санал хурааж дүнг мэдээлж, шийдвэрийг батлуулна.

2.28. Хурал нь өөрийн бүрэн эрхэд хамаарах зарим асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэх эрхээ Хурлын Тэргүүлэгчдэд шилжүүлж болох бөгөөд уг асуудлыг хуралд оролцсон Төлөөлөгчдийн олонхын саналаар шийдвэрлэнэ.

2.29. Хурал нь Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.4. дэх заалтын дагуу дүүргийн төсвийн асуудлыг төсвийн жил эхлэхээс өмнө хэлэлцэн батална.

2.30. Засаг захиргааны нэгжийн түүхэн ой, үйл явдлыг тэмдэглэх бол хугацаа урьдчилан товлохгүйгээр хүндэтгэлийн Хуралдаан зарлан хуралдуулж болно. Хурлын дарга хүндэтгэлийн хуралдаан хуралдуулах тухай захирамж гаргана.

Гурав. Анхдугаар хуралдаан

3.1. Анхдугаар хуралдааныг ээлжит сонгуулийн санал хураалт явуулсан өдрөөс хойш 20 хоногийн дотор бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болж буй Хурлын Тэргүүлэгчид зарлан хуралдуулах бөгөөд хуралдаан хийх газар, хэлэлцэх асуудлыг тогтооно.

3.2. Анхдугаар хуралдааныг шинээр сонгогдсон Төлөөлөгчдийн насаар хамгийн ахмад нь нээж шинээр сонгогдсон Төлөөлөгчдийн бүрэн эрхийг хүлээн

зөвшөөрүүлэх тухай асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж дуустал удирдан явуулах ба бусад асуудлыг шинээр сонгогдсон Хурлын дарга удирдан явуулна.

3.3. Анхдугаар хуралдааныг өмнөх Хурлын хүчин төгөлдөр үйлчилж буй хуралдааны дэгийн дагуу зохион байгуулна.

3.4. Анхдугаар хуралдаанаар Хурлын зохион байгуулалтын бүхий л асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ.

3.5. Анхдугаар хуралдаанаар Хурлын дарга, Тэргүүлэгч, Засаг даргад 2 ба түүнээс дээш нэр дэвшигч нэр дэвшвэл уг санал хураалтыг зохион байгуулах тооллогын ажлын хэсгийг Хурлын Төлөөлөгч, Хурлын Ажлын албаны ажилтны бүрэлдэхүүнтэйгээр байгуулна.

3.6. Тооллогын ажлын хэсгийн хамгийн олон санал авсан нэр дэвшигчийг сонгогдсонд тооцож тогтоол гаргана.

Дөрөв. Хурлын хуралдаанд асуудал оруулах эрх

4.1. Хурлын Төлөөлөгч, Тэргүүлэгч, хороо, нам, эвслийн бүлэг, дүүргийн Засаг дарга асуудал санаачлан Хуралд хэлэлцүүлэхээр оруулах эрхтэй.

4.2. Төрийн болон Төрийн бус байгууллага, Аж ахуйн нэгж, иргэн хуралд асуудал хэлэлцүүлэхээр санал дэвшүүлж болно.

4.3. Хуралдаанд хэлэлцүүлэх асуудлын илтгэл, тооцоо судалгаа, гарах шийдвэрийн төслийг асуудал санаачлагч нь эцэслэн бэлтгэж, Хурлын даргад өргөн барина.

4.4. Хуралд хэлэлцүүлэхээр өргөн барьсан асуудал нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3-т заасан шаардлагыг хангасан байна.

4.5. Хурлын дарга өргөн барьсан асуудлыг Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэн, нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэхээр төлөвлөгөөнд оруулах эсэх тухай асуудлыг шийдвэрлэнэ. Хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд оруулах боломжгүй бол энэ тухайгаа хариу мэдэгдэнэ.

4.6. Хуралдаанд хэлэлцүүлэхээр өргөн барьсан асуудлыг сайтар бэлтгэх, судалгаа дүгнэлт гаргах, нийт иргэдээр хэлэлцүүлэх зорилгоор Хурлын Тэргүүлэгчээр ахлуулсан ажлын хэсгийг байгуулж болно.

4.7. Хурлын Төлөөлөгч, хороо, нам, эвслийн бүлгээс Хурлын өөрийн дотоод асуудлаас бусад чиглэлээр асуудал хэлэлцүүлэхээр санаачилсан тохиолдолд Засаг даргын саналыг авна. Засаг дарга ажлын 14 хоногт багтаан санал өгөх бөгөөд өгөөгүй тохиолдолд өгөх саналгүйд тооцно.

Тав. Нам эвслийн бүлэг байгуулах, түүний ажлын зохион байгуулалт

5.1 Хуралд 5-аас доошгүй суудал авсан нам, эвсэл нь бүлэг байгуулсан тухай шийдвэр, бүлгийн ахлагч, гишүүдийн нэрсийн жагсаалтыг Анхдугаар хуралдааны даргад өргөн мэдүүлнэ.

5.2. Анхдугаар хуралдааны дарга нам, эвслийн бүлгийг тухайн хуралдаанд танилцуулах бөгөөд энэ асуудлаар аливаа хэлэлцүүлэг явуулахгүй.

5.3 Шинээр нөхөн сонгогдсон Төлөөлөгч аль нэг намын бүлэгт нэгдэн орвол түүнийг албан ёсоор мэдэгдэнэ.

5.4. Нам, эвслийн бүлэг нь хэлэлцэж байгаа асуудалтай холбоотойгоор санал, дүгнэлтээ гаргах, ажлын хэсэг байгуулах, хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах, нэгдсэн хуралдааны үед энэхүү дэгд заасны дагуу завсарлага авах, Тэргүүлэгчдийг сонгох, Засаг даргад нэр дэвшүүлэх, чөлөөлөх асуудалд санал оруулах эрхтэй.

Зургаа. Хурлын хороо тэдгээрийн ажлын зохион байгуулалт

6.1 Хурлын тасралтгүй, байнгын үйл ажиллагааг хангах, хуралдаанаар хэлэлцэх асуудлыг урьдчилан бэлтгэх, санал дүгнэлт гаргах, Хурлаас гарсан шийдвэрийн биелэлтийг хянан шалгах, чиг үүрэг бүхий хороог /цаашид хороо гэх/ байгуулан ажиллуулна.

6.2. Хурлаас цаг үеийн асуудлыг судлах, санал дүгнэлт боловсруулах, хянан шалгах үүрэг бүхий түр хороо, ажлын хэсэг байгуулан ажиллуулж болно. Түр хороо, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд тодорхой чиглэлээр мэргэжлийн байгууллагын туслалцаа авах, мэргэжилтэн, зөвлөх, асуудал хариуцсан ажилтан нарыг оруулж болох бөгөөд тэдгээрийн ажлын үр дүнг харьяалах хорооны хурлаар хэлэлцүүлж шаардлагатай тохиолдолд Хурлын хуралдаанд оруулна.

6.3. Хороодыг Төлөөлөгчдийн бүрэлдэхүүнтэйгээр Хурлын бүрэн эрхийн хугацаагаар Хурлаас байгуулах бөгөөд хороодын эрхлэх асуудал, үйл ажиллагааны журмыг Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэнэ. Хорооны даргыг тухайн хорооны Төлөөлөгчдийн дотроос сонгоно.

6.4. Төлөөлөгч нь 2-оос илүүгүй хороонд харьяалагдах ба бусад хороодын хуралдаанд оролцож, санал гаргах, үг хэлэх эрхтэй бөгөөд зөвхөн өөрийн харьяалагдах хорооны хуралд таслах эрхтэйгээр оролцоно.

6.5. Хорооны хурал нь тухайн хорооны Төлөөлөгчийн олонх нь хүрэлцэн ирснээр хүчин төгөлдөр болох бөгөөд асуудлыг олонхын саналаар шийдвэрлэнэ.

6.6. Хороо нь хэлэлцэж буй асуудлын талаар холбогдох байгууллага, албан тушаалтны илтгэл, сонсголыг хэлэлцэх, тооцоо, судалгаа, баримт материалыг гаргуулан авах, үйл ажиллагааг нь шалгах, шаардлага тавих, биелэлтийг хангуулах эрхтэй.

6.7. Хороо нь зөвхөн өөрийн эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаагаа явуулах бөгөөд хэлэлцсэн асуудлаараа санал дүгнэлт, зөвлөмж гарган Хурлын даргад өргөн мэдүүлнэ.

6.8. Хурлын дарга хороодоос ирүүлсэн санал, дүгнэлтийг Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэх ба нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэхээр өргөн барьсан шийдвэрийн төсөлд хороодын санал дүгнэлтийг тусгуулах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсний дараа төслийн эцсийн найруулгыг хийж, нэгдсэн хуралдаанд оруулна.

6.9. Хороо нь ажлын төлөвлөгөөг гаргаж, хийсэн ажлынхаа талаар нэгдсэн хуралдаанд жил тутам мэдээлж байна.

6.10. Хороодын үйл ажиллагааг тэдгээрийн ажиллах журмаар нарийвчлан зохицуулна.

Долоо. Хуралдааны шийдвэр

7.1. Хурал хэлэлцсэн асуудлаар тогтоол гаргах бөгөөд тогтоолын заалт бүрийг нарийвчлан хэлэлцэж, саналыг илээр хураах ба хуралдаанд оролцсон Төлөөлөгчдийн олонхын саналаар батлана.

7.2. Хурлын тогтоолд Хурлын дарга, Хурлын даргыг сонгох, чөлөөлөх тухай тогтоолд тухайн хуралдаан даргалагч тус тус гарын үсэг зурна.

7.3. Хурлын шийдвэрийг ёсчлон баталсаны дараа Хурлын Ажлын албанаас Хурал дахь нам, эвслийн бүлэг, Засаг даргын Тамгын газар бусад шаардлагатай байгууллагад ажлын 3 хоногийн дотор хүргүүлэх бөгөөд цахим хуудас, мэдээллийн самбарт байрлуулж олон нийтэд мэдээлнэ.

7.4. Хурлын шийдвэр нь хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрт нийцээгүй бол түүнийг Хурал өөрөө өөрчлөлт оруулах буюу хүчингүй болгоно.

7.5. Хурлын тогтоол, бусад баримт бичгийн төслийг нарийвчлан хянаж, санал, шүүмжлэлийг тусган, нягтлан боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Хурлын Төлөөлөгч, Ажлын албаны төлөөллийн бүрэлдэхүүнтэйгээр байгуулж болно.

7.6. Хуралдаан бүрт түүний үйл ажиллагааг нарийн тэмдэглэсэн тэмдэглэлийг хөтлөх ба хуралдаан дууссанаас хойш 10 хоногт багтаан хэлбэржүүлэх бөгөөд Хурлын дарга гарын үсэг зурж албажуулна.

7.7. Хуралдааны тэмдэглэлээр үүрэг, даалгавар, зөвлөмж, чиглэл өгч болох бөгөөд энэ нь Хурлын шийдвэрийн адил эрх зүйн чадамжтай байна.

Найм. Хурлын шийдвэрт хориг тавих

8.1. Хурал үндсэн хууль, бусад хууль тогтоомж зөрчсөн, эсхүл өөрийнх нь бүрэн эрхэд үл хамаарах, түүнчлэн хэрэгжих санхүүгийн болон бусад эх үүсвэргүй шийдвэр гаргасан бол Засаг дарга холбогдох шийдвэрт бүхэлд нь буюу түүний зарим хэсэгт хориг тавих эрхтэй.

8.2. Хуралдааны шийдвэрийн талаар Засаг даргаас хориг тавьсан нөхцөлд уг хоригийг хуралдаанаар хэлэлцэнэ. Засаг дарга хориг тавих болсон шалтгаанаа зүйлчлэн тусгасан албан бичгийг хуралд ирүүлнэ. Уг хоригийн хууль эрх зүй, эдийн засгийн үндэслэлийг нарийвчлан судлаж, олонхын саналаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

8.3. Засаг дарга хурлын шийдвэрт хориг тавьсан тохиолдолд Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу хэлэлцэн шийдвэрлэнэ.

8.4. Хурал Засаг даргын хоригийг зөв гэж үзвэл шийдвэрээ олонхын саналаар хүчингүй болгоно.

Ес. Хурал дах нам, эвслийн бүлэг завсарлага авах

9.1. Хурал дах нам, эвслийн бүлэг нь хуралдаанаар хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан завсарлага авч болох бөгөөд завсарлагын хугацааг нам эвслийн бүлгийн ахлагчтай зөвшилцөж Хурлын дарга тогтооно.

9.2. Нам эвслийн бүлэг хэлэлцэж буй асуудлаар завсарлага авсан бол хэлэлцэх асуудлын дараалалд орсон бусад асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцэнэ.

9.3. Завсарлага авах хугацаа нь 2 цагаас ажлын 2-оос илүүгүй өдөр байх бөгөөд шаардлагатай бол нэг удаа ажлын 1-ээс илүүгүй өдрөөр сунгах ба Хуралдаан даргалагч завсарлагын хугацааг зарлан мэдэгдэнэ.

Арав. Хуралдаан даргалагчийн эрх, үүрэг

10.1. Хуралдаан даргалагч нь хуралдааны дэг, дотоод журмын дагуу хуралдааныг удирдана.

10.2. Хуралдааныг хурлын дарга түүний эзгүйд Хурлын даргын санал болгосноор Тэргүүлэгчдийн аль нэг нь нээж удирдах бөгөөд хуралдаан зохион байгуулах талаар хуралдаан даргалагч дараах эрх үүргийг хэрэгжүүлнэ.

10.2.1. Хуралдааны товыг тогтоон зарлаж бэлтгэлийг хангах.

10.2.2. Хуралдааныг товлосон цагт эхлүүлж дэгийн дагуу зохион байгуулж, зөрчигдвөл таслан зогсоох.

10.2.3. Хуралдааны ажиллагааг нээж үг хэлэх, дүгнэж хаалтын үг хэлэх

- 10.2.4. Саналаа ирүүлсэн дарааллыг баримтлан Төлөөлөгчдөд асуулт асуух, үг хэлэх зөвшөөрөл өгөх.
- 10.2.5. Хуралдааны дэгд заасан зарчим, цаг хугацааг мөрдүүлэх, Төлөөлөгчдөөс ирүүлсэн асуулт, санал асуулгыг Төлөөлөгчдөд танилцуулах
- 10.2.6. Ирц хүрэлцэхүйц байвал хүндэтгэх шалтгаантай Төлөөлөгчид чөлөө өгөх.
- 10.2.7. Хэлэлцсэн асуудлаар Төлөөлөгчдийн саналыг хурааж, дүнг мэдээлж, эцсийн шийдвэрийг батлуулах
- 10.2.8. Хуралдааны үйл ажиллагааны ил тод байдлыг хангах арга хэмжээ авах
- 10.2.9. Хуралдааны шийдвэрийг хэлбэржүүлэх ажлыг зохион байгуулах.
- 10.2.10. Хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх, үүрэг

Арван нэг. Хурлын шийдвэрийг зохион байгуулах

11.1. Хуралдааны тогтоолыг мөрдөх хугацааг жичид нь заагаагүй бол уг хуралдаан болсон өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөнө.

11.2. Хуралдааны шийдвэрийг мэдээлж, сурталчилах, биелэлтийг зохион байгуулах ажлыг Хурлын Тэргүүлэгчид, Төлөөлөгчид, Хурлын Ажлын алба, Засаг дарга түүний тамгын газар, хэлтэс албад, хэвлэл мэдээллийн байгууллага хариуцна.

11.3. Хуралдааны тухай мэдээ, хуралдаанд оруулсан илтгэл, тогтоолыг Хурлын ажлын албанаас 5 хоногийн дотор хэвлэлд нийтлэн, байгууллагын цахим хуудсанд байршуулж сурталчилна. Хурлын шийдвэрийг хэвлэлд нийтлэх, холбогдох байгууллагад хүргэх асуудлыг Хурлын дарга, Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын зөвшөөрлөөр хийнэ.

11.4. Хурлын шийдвэрийн биелэлтийг хангах хүрээнд хэрэгжүүлж буй ажлын явц, үр дүнгийн талаар дүүргийн Засаг дарга түүний Тамгын газар, дэргэдэх хэлтэс, алба, нутаг дэвсгэр дэх байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаатай нь танилцах, үзлэг, шалгалтын ажлыг зохион байгуулах, тэдгээрийн удирдлага, албан тушаалтны илтгэл сонсголыг хэлэлцэж, үйл ажиллагаанд нь үнэлэлт, дүгнэлт өгч ажиллана.

11.5. Хурлын шийдвэрийн биелэлт, хурлын тэмдэглэлээр өгсөн үүргийн биелэлтийн талаар хагас жил тутам Тэргүүлэгчдэд танилцуулж байна.

11.6. Хурлын шийдвэрийн биелэлтийн талаар Хурал түүний Тэргүүлэгчид тусгайлан хэлэлцэж чиглэл өгөх, хугацаатай даалгавар өгөх, шаардлага тавих, хариуцлага тооцох зэргээр ажиллаж гаргасан шийдвэрээ ажил хэрэг болгохын төлөө ажиллана.

11.7. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн дагуу хурлын шийдвэр биелүүлээгүй албан тушаалтанд хариуцлага тооцож байна.

Арван хоёр. Хурлын дэг хүчин төгөлдөр болох

12.1. Энэхүү Хурлын дэг батлагдсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилнэ.

12.2. Хуралдааны дэгд нэмэлт өөрчлөлт оруулах тухай асуудлыг Хурлын Төлөөлөгчдийн гуравны хоёроос доошгүйн саналаар ээлжит хуралдаанаар хэлэлцүүлнэ. Нэмэлт өөрчлөлтийг хуралдаанд оролцсон Төлөөлөгчдийн олонхын саналаар батална.



НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2016 оны 11 сарын 21 өдөр

Дугаар 07

Улаанбаатар хот

Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын дүрэм батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх заалтыг үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны дүрмийг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.
2. Хурлын дүрмийг мөрдөж ажиллахыг Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчид, Хурлын Ажлын албаны ажилтнуудад үүрэг болгосугай.
3. Энэхүү дүрэм батлагдсантай холбогдуулан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2012 оны 09 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ХУРЛЫН ДАРГА



Д.БАТ-ЭРДЭНЭ

1150100019

Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын 2016 оны 11 дүгээр сарын
21-ний өдрийн 07 тогтоолын хавсралт

**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ДҮРЭМ**
/шинэчилсэн найруулга/

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү дүрмийн зорилго нь Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Тэргүүлэгчид түүний Ажлын алба, Хурлын хороо, түр хороо, ажлын хэсэг, хурал дахь нам, эвслийн бүлэг түүний Ажлын албаны үйл ажиллагааны зарчим, чиглэлийг тогтоох, зохион байгуулалт, үйл ажиллагааг нь нарийвчлан зохицуулахад оршино.

1.2. Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зохион байгуулалт, үйл ажиллагаа, бүтэц бүрэлдэхүүн, эрх, үүргийг Монгол Улсын Үндсэн хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж болон энэ дүрмээр зохицуулна.

1.3. Хурал нь Монгол Улсын Үндсэн хууль, холбогдох бусад хууль тогтоомж, энэхүү дүрмийг үндэс болгон дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны дэг, Хурлын Тэргүүлэгчид, Хороодын ажиллах журам, Хурлын Төлөөлөгчдийн оролцоог дүгнэх, урамшуулал олгох журам, аргачлал, Хурлын Ажлын албаны хөдөлмөрийн дотоод журмыг батлан мөрдөж ажиллана.

1.4. Хурал нь үйл ажиллагаандаа ардчилсан ёс, шударга ёс, хүний эрх, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх зарчмыг баримтлан нутгийн өөрөө удирдах ёсыг Төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр хэрэгжүүлнэ.

Хоёр. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал түүний бүрэлдэхүүн

2.1. Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь /цаашид Хурал гэх/ Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, яам, агентлаг, дээд шатны Хурал болон Төрийн эрх барих бусад байгууллага, албан тушаалтанд хуулиар харьяалуулснаас бусад дүүргийн эдийн засаг, нийгмийн болон зохион байгуулалтын ямар ч асуудлыг бие даан хэлэлцэн шийдвэрлэх эрх бүхий нутгийн өөрөө удирдах байгууллага мөн.

2.2. Хурал нь орон нутгийн хурлын сонгуулиар Хурлын Төлөөлөгчөөр сонгогдож, бүрэн эрх нь баталгаажсан, дүүргийн нийгэм, эдийн засгийн асуудлыг хэлэлцэн шийдвэрлэхэд таслах эрхтэй Төлөөлөгчдөөс бүрдэнэ.

2.3. Хурлын Төлөөлөгч нь сонгогдсон дүүргийнхээ иргэдийн элч, төлөөлөгч мөн бөгөөд дүүргийн нийт иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална.

2.4. Хурал нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18-22 дугаар зүйлд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлж, 23-25 дугаар зүйлд заасны дагуу үйл ажиллагаагаа зохион байгуулна.

2.5. Хурал нь хуулиар зөвшөөрөгдсөн хороо, түр хороо, ажлын хэсэг, Ажлын албыг байгуулах бөгөөд тэдгээр нь хурлын бүрэлдэхүүн хэсэг мөн.

2.6. Хорооны Иргэдийн Нийтийн Хурал нь нутгийн өөрөө удирдах байгууллагын бүрэлдэхүүн хэсэг мөн бөгөөд дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид хорооны Иргэдийн Нийтийн Хурлын Тэргүүлэгчдийг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд нь дэмжлэг туслалцаа үзүүлнэ.

2.7. Хурлын үйл ажиллагааны зохион байгуулалтын үндсэн хэлбэр нь Хурлын Төлөөлөгчид, Тэргүүлэгчид, хороо, түр хороо, ажлын хэсгийн хуралдаанаас гадна нам, эвслийн бүлэг, Ажлын албаны хурал, иргэд сонгогчидтой хийх уулзалт, ярилцлага, зөвлөгөөн, хэлэлцүүлэг зэрэг бусад хэлбэрээр хэрэгжинэ.

2.8. Хурлын хуралдааны чөлөөт цагт түүний бүрэн эрхийг Тэргүүлэгчид хэрэгжүүлнэ.

2.9. Хурлын үйл ажиллагаа, зохион байгуулалтын бусад хэлбэрт Хурлаас байгуулсан хороо, түр хороо, ажлын хэсгийн үйл ажиллагаа хамаарах бөгөөд тэдгээрийн үйл ажиллагааг Хурлын хуралдаанаас баталсан журмын дагуу зохицуулна.

2.10 Хурал нь бүрэн эрхээ хэрэгжүүлэх, шийдвэрийнхээ биелэлтийг хянан шалгах, цаг үеийн асуудлыг судлах, санал дүгнэлт боловсруулах зорилгоор Төлөөлөгчид, Ажлын алба, холбогдох мэргэжилтэн, шинжээч нараас бүрдсэн түр хороо, ажлын хэсгийг байгуулж болно. Үйл ажиллагааны чиглэл, удирдамжийг Хурлын дарга батална.

2.11. Хуралд 5-аас доошгүй суудал авсан нам, эвсэл бүлэг байгуулж болох бөгөөд нам эвсэл нь бүлэг байгуулах шийдвэр, бүлгийн дарга, гишүүдийн нэрсийг Хурлын даргад өргөн мэдүүлсэнээр байгуулагдсанд тооцно.

2.12. Хурал дахь нам, эвслийн бүлэг нь Ажлын албатай байх бөгөөд ажиллах журам, орон тоо, зардлыг Тэргүүлэгчид батлах бөгөөд дотоод зохион

байгуулалтаа өөрсдөө шийдвэрлэх ба тэдгээрийн ажиллах нөхцөлийг Хурлын Ажлын алба хангана.

2.13. Нам, эвслийн бүлгүүд ажлын төлөвлөгөө, түүний хэрэгжилтийг улирал тутамд Хурлын Ажлын албанд ирүүлнэ.

2.14. Хурал нь өөрийн төсөвтэй, банкинд харилцах данстай, эд хөрөнгөтэй байна. Хурал нь орон нутгийн төсвөөс санхүүжих бөгөөд төсвийн ерөнхийлөн захирагч нь Хурлын дарга, шууд захирагч нь Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга байна.

2.15. Хурал нь төсвөө бие даан боловсруулж Орон нутгийн төсөвт тусгана.

2.16. Хурал нь өөрийн нэрэмжит шагналтай байх ба шагналын төрөл, олгох журмыг Хурлын Тэргүүлэгчид тогтооно.

2.17. Хурал нь дэргэдээ Улс Төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийг цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах салбар комисс, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл зэрэг хууль тогтоомжид заасан орон тооны бус нэгжийг ажиллуулахаас гадна өөрийн санаачлагаар бусад комисс, зөвлөлийг ажиллуулж болно.

2.18. Хурал нь бие даасан хуулийн этгээд бөгөөд Улсын бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлд заасан журмаар бүртгүүлж, Улсын бүртгэлийн гэрчилгээ авна.

2.19. Хурал нь тогтоосон журмаар үйлдсэн тамга, тэмдэг, хэвлэмэл хуудастай байна. Хурлын тамгыг Хурлын дарга, тэмдэгийг Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга хэрэглэнэ.

2.20. Нам, эвслийн бүлгүүд хэвлэмэл хуудас, тэмдэг хэрэглэх бөгөөд Төлөөлөгчийн байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтанд явуулах албан бичигт харьяалах Нам, эвслийн бүлгийн тэмдгийг дарж баталгаажуулна.

Гурав. Хурлын хуралдаан

3.1. Дүүргийн Хурлын эрх хэмжээнд хамаарах нутаг дэвсгэрийн нийгэм, эдийн засгийн бүхий л асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх үйл явцыг Хурлын хуралдаан гэнэ.

3.2. Хурлын хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлыг Хурлын Тэргүүлэгчид болон холбогдох хороо, түр хороо, Хурал дахь намын бүлгийн хуралдаанаар урьдчилан хэлэлцүүлж, холбогдох байгууллага, албан тушаалтны илтгэл, мэдээллийг сонссон байна.

3.3. Хурлын хуралдааны үйл ажиллагааг Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 23 дугаар зүйл, Хурлын хуралдааны дэгийн дагуу зохион байгуулах бөгөөд дэгийг Хурал өөрөө батална.

3.4. Хурлын хуралдаан нь нээлттэй байх бөгөөд хуралдааны үйл ажиллагаатай танилцах хүсэлтэй иргэд, иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтныг оролцуулах асуудлыг хуралдааны дэгээр зохицуулна.

3.5. Хурлын шийдвэр нь тогтоол хэлбэртэй байх бөгөөд хуралдааны тэмдэглэлээр үүрэг, даалгавар, зөвлөмж, чиглэл өгч болох бөгөөд энэ нь Хурлын шийдвэрийн адил эрх зүйн чадамжтай байна.

3.6. Хурлын тогтоол бусад шийдвэрийг ёсчилсоноос хойш Хурлын даргын зөвшөөрснөөр хэвлэл мэдээлэл, олон нийтэд мэдээллэх ба хуралдааны шийдвэр тэдгээрийн хэрэгжилтийн талаар үнэн зөв мэдээллийг Хурлын Төлөөлөгчид, Тэргүүлэгчид түүний Ажлын алба иргэдэд сурталчилна.

Дөрөв. Хурлын Төлөөлөгч түүний эрх, үүрэг, баталгаа

4.1. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгч нь нутгийн өөрөө удирдах байгууллагад сонгогдсон тойргийнхоо иргэдийн Төлөөлөгч мөн бөгөөд дүүргийнхээ эдийн засаг, нийгмийн бүхий л асуудлыг хэлэлцэн шийдвэрлэхэд таслах эрхтэй оролцоно.

4.2. Хурлын Төлөөлөгч нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэхээс гадна дараах үүргийг хүлээнэ.

4.2.1. Хурлын Төлөөлөгч нь хурлаас байгуулсан хороо, түр хороо, ажлын хэсэгт хуваарилсаны дагуу ажиллах ба Хурлын хуралдаан, хороо, түр хороо ажлын хэсэгт тогтмол оролцож, олонхын саналаар шийдвэрлэсэн асуудалд хүндэтгэлтэй хандах

4.2.2. Сонгогдсон тойрог, хорооныхоо иргэд, сонгогчдоо төлөөлөх, тэдэнтэй байнгын холбоотой ажиллах, сонгогчдын өмнө дэвшүүлсэн мөрийн хөтөлбөрөө биелүүлэх

4.2.3. Хууль тогтоомж, дүрэм, журам, хуралдааны дэгийг чанд сахих

4.2.4. Хурлын Төлөөлөгчийн хувьд үг хэлэх, санал дүгнэлт гаргахдаа асуудалд нотолгоотой, хариуцлагатай хандах

4.2.5. Хурлын Ажлын алба бусад байгууллагаас зохион байгуулсан сургалт, зөвлөгөөн, арга хэмжээнд идэвхтэй оролцох

4.2.6. Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг тогтоосон хугацаанд холбогдох хууль журмын дагуу үнэн зөв мэдүүлэх

4.3. Хурлын Төлөөлөгч нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасан баталгаагаар хангагдахаас гадна дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй төр

захиргааны болон аж ахуйн нэгж байгууллагад саадгүй нэвтэрч, холбогдох албан тушаалтантай уулзах, бичиг баримттай нь танилцах зэргээр төр байгууллага, хувь хүний нууцад хамаарахаас бусад аливаа мэдээллийг авах эрхтэй.

4.4. Хурлын Төлөөлөгчийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь Хурлын Ажлын алба арга зүйн, Засаг даргын Тамгын газар, хэлтэс албад мэдээ, мэдээлэл, техник зохион байгуулалтын нөхцөлөөр хангаж ажиллана.

4.5. Хурлын Төлөөлөгч нь бүрэн эрхийнхээ хугацаанд үнэмлэх, энгэрийн тэмдэг, хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

4.6. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлэх, түүнийг чөлөөлөх, эгүүлэн татах эсэх асуудлыг эрх бүхий байгууллагын шийдвэрийг үндэслэн зөвхөн Хурлын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

4.7. Хурлын Төлөөлөгч нь бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардагдах үйл ажиллагааны зардал, урамшуулалтай байна. Үйл ажиллагааны зардал, урамшууллыг Хурлын Тэргүүлэгчдийн шийдвэрээр олгоно.

4.8. Хурлын Төлөөлөгч Хурлын даргын баталсан удирдамжийн хүрээнд хороо, түр хороо ажлын хэсэгт орж ажиллахдаа гишүүний хувиар орон нутагт ажилласан бол үйл ажиллагааны болон томилолтын зардлыг нь олгоно.

4.9. Хурлын Төлөөлөгчдөд дараах буцалтгүй тусламжийг олгоно.

4.9.1. Хурлын Төлөөлөгч болон эхнэр /нөхөр/, хүүхэд, төрсөн эцэг, эх, хадам эцэг, эх нь нас барсан эсвэл удаан хугацаанд хүндээр өвчилсөн бол түүний ар гэрт 1000000 /нэг сая/ төгрөгийн

4.9.2. Хурлын Төлөөлөгч нь Монгол Улсад эмчилгээ оношлогоо хийгдэх боломжгүй хүндээр өвчилсөн бол эрх бүхий байгууллагын дүгнэлтээр гадаад улсад эмчилгээнд явах шаардлагатай бол 5000000 /таван сая/ хүртэлх төгрөгийн

4.10. Хурлын Төлөөлөгч, Тэргүүлэгчид, хорооны үйл ажиллагааны зардалд шаардагдах санхүүжилтийг Хурлын жил бүрийн төсөвт тусган батална.

Тав. Хурлын Ажлын алба түүний зохион байгуулалт

5.1. Хурлын үйл ажиллагааг Төрийн албаны стандартын дагуу зохион байгуулж, Хуралдааны бэлтгэл хангах, гарсан шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, Хурал, Тэргүүлэгчдийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх чиг үүрэг бүхий Ажлын алба ажиллана.

5.2. Хурлын Ажлын албаны орон тоо, цалингийн санг Тэргүүлэгчид батлах бөгөөд ажилтнуудын ажил үүргийн хуваарь, ажлын байрны тодорхойлолт,

хөдөлмөрийн дотоод журмыг Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга баталж, мөрдүүлнэ.

5.3. Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргыг Хурлын Тэргүүлэгчидтэй зөвшилцөн Хурлын дарга томилж, чөлөөлөх бөгөөд Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга Хурлын даргатай үр дүнгийн гэрээ байгуулан ажиллана.

5.4. Хурлын Ажлын албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалд Төрийн захиргааны, туслан гүйцэтгэх албан тушаалд Төрийн үйлчилгээний болон Улс төрийн албан хаагчид ажиллах ба тэдгээрийн эрх зүйн байдлыг Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон бусад хууль эрх зүйн актаар зохицуулна.

5.5. Хурлын Ажлын алба нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

5.5.1. Хурал, Тэргүүлэгчдийн тогтоол, бусад шийдвэр гаргахад нь дэмжлэг үзүүлж, шийдвэрийн биелэлтэнд тавих хяналт шалгалтын ажлыг зохион байгуулах

5.5.2. Хурал, Тэргүүлэгчид, Хурлын хороо, түр хороо, ажлын хэсгийн хуралдаанаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, холбогдох тооцоо, судалгаа, зар мэдээллийг Төлөөлөгчдөд хүргэх

5.5.3. Хуралдааны байр танхим, шаардлагатай техник хэрэгслийг бэлэн байлгах, хуралдааны явцын тэмдэглэл, шийдвэрийг хэлбэржүүлэн гаргах, нийтэд мэдээллэх

5.5.4. Хурал, Тэргүүлэгчдийн шийдвэрийг биелүүлэх үүрэг бүхий байгууллага, албан тушаалтанд хүргэж, гүйцэтгэлд хяналт тавьж, үр дүнг нэгтгэн тодорхойлох

5.5.5. Ерөнхийлөгч болон Улсын Их Хурал, Нийслэл, дүүргийн хурлын сонгуулийг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах

5.5.6. Хуулийн төсөл, Хурал, Тэргүүлэгчдээс гарах шийдвэрийн төслийг иргэдээр хэлэлцүүлэх, санал асуулга явуулах ажлыг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах

5.5.7. Хурал, Тэргүүлэгчдэд иргэд байгууллагаас ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл гомдол мэдээллийг хүлээн авч зохих журмын дагуу шийдвэрлүүлэх арга хэмжээ авах

5.5.8. Хурал, Тэргүүлэгчдээс баталсан тогтоол, шийдвэрийг иргэд олон нийтэд үнэн зөв сурталчилан таниулах ажлыг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах

5.5.9. Хурлын Төлөөлөгчдийн сонгогдсон тойрог хорооны иргэдтэй хийх уулзалт, ярилцлага, зөвлөгөөнийг зохион байгуулах, Төлөөлөгчийн тойрогтоо ажиллах нөхцөлийг хангаж ажиллах

5.5.10. Хурал, Тэргүүлэгчдийн гадаад, дотоод харилцааны асуудлын шаардлагатай бичиг баримтыг боловсруулах, бэлтгэх, албан ажлын шугамаар гадаад оронд айлчлах, гадаад зочид, Төлөөлөгчдийг хүлээн авах ажлыг зохион байгуулах

5.5.11. Хурлын Төлөөлөгчдөд зориулсан сургалт, зөвлөгөөн, уулзалт, хэлэлцүүлэг бусад арга хэмжээг зохион байгуулах

5.5.12. Хурал, Тэргүүлэгчдийг шаардлагатай мэдээ мэдээлэл, ном, гарын авлагаар хангах

5.6. Хурлын Ажлын алба нь өөрийн чиг үүргийг хэрэгжүүлэхдээ дүүргийн Засаг даргын Тамгын газар, түүний харьяа хэлтэс, албадтай нягт хамтран ажиллана.

5.7. Хурлын Ажлын алба ажлаа жилд 1-ээс доошгүй удаа дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулна.



**НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2016 оны 11 сарын 21 өдөр

Дугаар 08


Улаанбаатар хот

**Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Ёс зүйн дүрэм батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх заалтыг үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдийн Ёс зүйн дүрмийг хавсралт ёсоор баталсугай.
2. Хурлын Төлөөлөгчдийн Ёс зүйн дүрмийг мөрдөж ажиллахыг Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдөд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Д.БАТ-ЭРДЭНЭ

Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын 2016 оны 11 дүгээр сарын
21-ний өдрийн 08 тогтоолын хавсралт



НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ЁС ЗҮЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчөөс бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ баримтлах зарчим, ёс зүйн хэм хэмжээг тогтоон мөрдүүлж, нутгийн өөрөө удирдах байгууллагыг хуулийн хүрээнд ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, хувийн ашиг сонирхолын нөлөөлөөс хамгаалах, төр, олон нийтийн итгэлцэлийг бэхжүүлэхэд энэхүү дүрмийн зорилго оршино.

1.2. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгч / цаашид “Төлөөлөгч” гэх/ нь үйл ажиллагаандаа энэ дүрмээр тогтоосон ёс зүйн хэм хэмжээг баримтлахын зэрэгцээ Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Сонгуулийн тухай хууль, Авилгын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхолыг зохицуулах, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан хэм хэмжээг дагаж мөрдөнө.

Хоёр. Албаны үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн хэм хэмжээ

2.1. Төлөөлөгч нь бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ Монгол Улсын хуулийг дээдлэн сахих, аливаа асуудалд шударга байр сууринаас хандах, бусдын нэр төр, алдар хүнд, эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхолыг хүндэтгэх зарчмын хүрээнд дараах ёс зүйн хэм хэмжээг баримтлана.

2.1.1. Бусдын нэр төр, алдар хүнд, хууль ёсны ашиг сонирхлыг нь эрхэмлэн, хүндэтгэлтэй хандах

2.1.2. Хуулиар олгосон бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ төр, олон нийтийн холбоог бэхжүүлэх

2.1.3. Бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотойгоор хүлээн авсан нууцад хамаарах аливаа мэдээлэл, бичиг баримттай танилцахдаа нууцын талаарх хууль тогтоомжийг баримтлах

2.1.4. Бүрэн эрхийнхээ хугацаанд үнэмлэх, энгэрийн тэмдэг, албаны хэвлэмэл хуудсыг зөвхөн албан хэрэгцээнд тогтоосон журмын дагуу хэрэглэх

2.1.5. Нутгийн захиргааны болон төрийн захиргааны байгууллагаас албан үүргийн хүрээнд хамаарах асуудлаар туслалцаа дэмжлэг авахдаа зохих журмыг баримтлах

2.1.6. Нутгийн захиргааны байгууллагын байранд болон Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчийн Хурлын танхимд биеэ зөв авч явж, холбогдох хууль тогтоомжийг сахин биелүүлэх

2.1.7. Хууль зөрчсөн, иргэдийн нийтлэг эрх ашигт харшилсан, шударга бус явдалтай эвлэрэхгүй байх

2.1.8. Бүрэн эрхээ шашны эсхүл шашингүй үзлийн ухуулга, сурталчилгаа хийхэд ашиглахгүй байх

2.1.9. Албаны бус зорилгод төрийн болон орон нутгийн байгууллагын эд хөрөнгө, техник хэрэгсэл, санхүүгийн эх үүсвэр, мэдээллийн хангамж болон албаны мэдээллийг ашиглахгүй байх

2.1.10. Төлөөлөгч бүрэн эрхийнхээ хугацаанд зүй зохисгүй байдал гаргахгүй байх, ёс зүйн хэм хэмжээг сахих талаар олон нийтэд үлгэр жишээ үзүүлэгч байх

2.1.11. Байгаль орчинд халтай үйлдэл хийхгүй байх, ийм үйлдлийг дэмжсэн санал, санаачилга гаргахгүй байх

Гурав. Ашиг сонирхолын зөрчилтэй холбоотой ёс зүйн хэм хэмжээ

3.1. Төлөөлөгч нь орон нутгийн иргэдийн улс орны нийтлэг ашиг сонирхолыг эрхэмлэн, хүнийг ялгаварлан гадуурхахгүй, тэгш хандах зарчмын хүрээнд ёс зүйн хэм хэмжээг баримталж, дараах үйлдэл хийхийг хориглоно.

3.1.1. Бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь зориулан олгогдсон төрийн болон орон нутгийн байгууллагын эд хөрөнгө, техник хэрэгсэл, санхүүгийн нөөц болон бусад мэдээллийг албан ажлынхаас бусад хэрэгцээнд ашиглах

3.1.2. Зохих зөвшөөрөлгүйгээр Монгол улс, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжтэй холбоотой аливаа асуудлаар гадаадын байгууллага, албан тушаалтанд амлалт өгөх, хувийн эрх үзэл бодлоо илрэхийлэх

3.1.3. Албан тушаалын үүрэг, хариуцлагатай нь харшилсан санхүү, худалдааны болон бусад ижил төстэй ямар ч хэлбэрийн хэлэлцээрт оролцох

3.1.4. Төрийн болон орон нутгийн өмч, үйлчилгээ болон мэдээлэл /ажил үүргийн дагуу олж авсан мэдээлэл мөн өөрийн ажил үүрэгт холбогдолгүй ч албан тушаалынхаа хүрээнд олж авсан мэдээлэл/-ийг хууль бусаар ашиглах

3.1.5. Хүнийг аливаа хэлбэрээр ялгаварлах, жендерийн шууд ба шууд бус хэлбэрээр ялгаварлан гадуурхах

3.2. Төлөөлөгч аж ахуйн нэгж, байгууллагын болон санхүүгийн нөлөөнд автахгүй байх, албаны эрх үүргээ хувийн зорилгоор ашиглахгүй байх үүднээс холбогдох хууль тогтоомжийг мөрдөх бөгөөд дараах үйлдэл хийхийг хориглоно.

3.2.1 Бүрэн эрхээ хэрэгжүүлэх явцдаа өөрийн нэр хүнд, эрх мэдлийг ашиглан эд хөрөнгө олж авах, давуу эрх эдлэх, бусдад давуу байдал олгох үйл ажиллагаа явуулах, бусдад нөлөөлөх оролдлого хийх

3.2.2 Бүрэн эрхийнхээ хүрээнд асуудал боловсруулж шийдвэрлэх болон хууль ёсны шийдвэр гаргахад нь бусдад нөлөөлөх

3.2.3. Албан тушаалын хувьд ижил зэрэг зиндааны болон өөрт нь захирагддаг эсхүл үйл ажиллагаанд нь хяналт тавьдаг албан тушаалтанд хууль бусаар нөлөөлөхийг оролдох

3.2.5. Албан тушаалынхаа байдлыг ашиглаж хууль бус орлого, ашиг хонжоо, давуу тал олох зорилготой бусад үйлдэл хийх

3.3. Төлөөлөгч нь хууль тогтоомжоор хориглосон, ашиг сонирхолын хувьд зөрчил үүсгэж болзошгүй аливаа ажил, албан тушаал эрхлэх, түүнчлэн цалин хөлс, урамшуулал авах, өгөхийг шаардахыг хориглоно.

Дөрөв. Хөрөнгө, орлогын мэдүүлэг, албан томилолттой холбогдсон ёс зүйн хэмжээ

4.1. Төлөөлөгч хууль тогтоомжид заасан хугацаа, журмын дагуу хөрөнгө орлогын мэдүүлгээ үнэн зөв гаргах үүргээ сахин биелүүлнэ.

4.2. Төлөөлөгч иргэдийн боловсролыг дээшлүүлэх, оюуны хөгжилд хувь нэмэр оруулах зорилгоор яриа хийх, илтгэл тавих, өгүүлэл, ном бичсэнийхээ төлөө урамшуулал авч болох бөгөөд энэхүү орлогоо хөрөнгө, орлогын мэдүүлэгт заавал тусгана.

4.3. Төлөөлөгч гадаад, дотоодод албан томилолт, аялалаар явахдаа эрх бүхий албан тушаалтны шийдвэрийг гаргуулах ба удирдамж, чиглэлийг чанд баримтлан, ажлын тайланг удирдамжид заасан хугацаанд Хурлын Ажлын албанд гаргаж өгөх үүрэгтэй.

Тав. Шагнал, бэлэг дурсгал хүлээн авахтай холбогдсон ёс зүйн хэм хэмжээ

5.1. Төлөөлөгч нь Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нэр хүндэд харш үйлдэл хийхгүй байх зарчмын хүрээнд дараах ёс зүйн хэм хэмжээг баримтлана.

5.1.1. Албан үүргээ хэрэгжүүлснийхээ төлөө болон хийж гүйцэтгэхээр төлөвлөж байгаа аж ахуйн нэгжээс мөнгөн шагнал, шан харамж, зээл авах, хөнгөлөлттэйгээр үйлчлүүлэх, хууль бусаар бусад бэлэг авах, хангамж эдлэхгүй байх

5.1.2. Эрх мэдлийнхээ хүрээнд хянан шалгаж байгаа байгууллага, албан тушаалтнаас хуульд заасан журмаас гадуур бэлэн мөнгө болон мөнгөөр үнэлэгдэх үнэт зүйлс авахгүй байх

Зургаа. Сонгуулийн сурталчилгаа ажлын үеэр баримтлах ёс зүйн хэм хэмжээ

6.1. Төлөөлөгчид бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй нь холбогдуулан олгосон ажлын байр, санхүүгийн эх үүсвэр, холбоо, мэдээлэл, тээврийн хэрэгсэл, төрийн болон орон нутгийн албан хаагчийг сонгуулийн сурталчилгааны ажилд ашиглахыг хориглоно.

Долоо. Бусад

7.1. Энэ дүрмийн биелэлтэд Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэдэх Ёс зүй, өргөдлийн хороо хяналт тавин ажиллах бөгөөд уг хорооны ажиллах журмыг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдааны тогтоолоор батлана.